



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/122

Шивээговь сум

Үнэлгээний хороог өөрчлөн  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2023 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Сумын 1 дүгээр багт хийгдэх нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр өөрчлөн байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Г.Номин-Эрдэнэ

(Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Ё.Батцэнгэл

(“Шивээ Овоо” хувьцаат компанийн тээвэр үйлчилгээний механик)

Б.Цогт-Эрдэнэ

(“Шивээ Овоо” хувьцаат компанийн Хяналтын мэргэжилтэн)

Ц.Эрдэнэбат

(Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга:

Б.Алтансүх

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Дээрх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, тендер шалгаруулалтын шударга байдлыг хангаж ажиллахыг үнэлгээний хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг бүртгэн тайланд тусгаж, эзэмшил ашиглалтад хяналт тавин ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/77 дугаар тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА